

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшин, гүйцэтгэл.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ТӨААТҮГ-ЫН ДАРГА Б.УНДРАМ
ТАНАА

2020.03.13 № 06/791
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Ундрам Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зардлын ангиллыг зөв бүртгэх талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 01-ээс 2020 оны 02 дугаар сарын 16-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Эвиденсе аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 54 дүгээр албан тоотоор ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Засгийн газрын байруудад байрлан үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах орчин нөхцөлийг бий болгох, тэдгээр байгууллагуудын нийтлэг үйлчилгээг чанар, стандартын дагуу чанартай түргэн шуурхай үзүүлэхэд оршино.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хүрээнд үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангаж үйлчилгээг холбогдох шийдвэр, гэрээ, захиалга, стандартын дагуу эрхлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;
- Засгийн газрын байруудын дотоод болон гадна орчны цэвэрлэгээ, ариун цэвэр тохижилт, засварыг хариуцаж, байр ашиглалтын нийтлэг үйлчилгээг гүйцэтгэх;
- Балансид бүртгэлтэй төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалттай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон бусад үйлчилгээний байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, хамтран ажиллах;
- Нийтлэг үйлчилгээний мэргэшсэн ажилтан бэлтгэх, давтан сургах, ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын хуульд шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувьд өөрчлөлт орсныг мөрдөн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь боловсруулалтын шатанд байгаа учраас Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон 5,442.2 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 54.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцсон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 56.9 сая төгрөгөөр тооцсон болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 521.8 сая төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	619.0	759.3	140.3
Авлага	26.6	32.1	5.5
Бараа материал	356.1	378.8	22.7
Үндсэн хөрөнгө	9,021.6	9,374.9	353.3
Нийт хөрөнгө	10,023.3	10,545.1	521.8
Өр төлбөр	92.7	72.0	-20.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,930.6	10,473.1	542.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,023.3	10,545.1	521.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөр Засгийн газрын байруудын их засварын зардлын санхүүжилт 161.9 сая төгрөг орсонтой холбоотойгоор өссөн.

Авлага дансны өсөлт нь 2019 онд цайны газрын түрээслэгчээс авах 5.9 сая төгрөгийн авлагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн тайлант хугацааны худалдан авалтаас шалтгаалжээ. Мөн 43.2 сая төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дээврийн их засварын 927.3 сая төгрөгийн ажлыг капиталжуулсантай холбоотой. Мөн 22.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, компьютер шилжүүлсэн, тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 798.8 сая төгрөг байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 131 тоот тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн 125.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан.

Биет бус хөрөнгө тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 32.1 сая төгрөгийн барьцаа төлбөр, ажил үйлчилгээний түрээсийн гэрээтэй байгууллагуудаас тайлант хугацаанд орсон урьдчилж орсон орлого 39.9 сая төгрөг байна. Нийт өр төлбөрийн 44 хувийг барьцаа баталгааны өглөг эзэлж байна.

Эздийн өмчийн өсөлт нь тайлант хугацаанд гарсан урсгал засварын зардлыг капиталжуулсантай холбоотой.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь 2019 онд зорилтот түвшингийн төлөвлөгөөнд орлогыг үндсэн үйл ажиллагааны орлого 5,106.7 сая төгрөг, өмчийн орлого 94.4 сая төгрөг, бусад орлого 33.7 сая төгрөг нийт 5,234.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 5,225.8 сая төгрөг, өмчийн орлого 206.0 сая төгрөг, бусад орлого 13.3 сая төгрөг, хүүгийн орлого 36.3 сая төгрөг, нийт 5,481.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 246.6 сая төгрөг буюу 5 хувиар давуулан биелүүлжээ.

Зорилтот түвшингийн 2019 оны нийт үйл ажиллагааны зардалд 5,234.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 5,696.5 сая төгрөг зарцуулж 461.5 сая төгрөг буюу 9 хувиар зардлыг хэтрүүлж, 215.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт өөрийн орлогын 30 хувь болох 39.6 сая төгрөг төвлөрүүлжээ.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 24.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 24.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2.12. Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв гүйцэтгэлийн 26, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 27, бусад 57 мэдээллийг хугацаанд нь оруулж, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,861.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна Өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмуудын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Харуул хамгаалалтын албаны 12 дугаар сарын зардлын 10,165.0 мянган төгрөгийн өглөг үүсгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө” заалтыг зөрчсөн

3.1.2 Эрсдэл: Тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Орлого зардлыг аккруз сууриар бүртгэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг дахин давтахгүй анхаарч ажиллана.

3.2 Шатахууны зардал, тайлагналтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд гарсан 14,254.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг удирдлагын зардлын ангилалд тэвэрийн зардлаар бүртгэж шатахууны зарцуулалтын тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.”Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.”үнэн зөв байх”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын 20.1 “Борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал” заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Зардлын ангилал буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Зардлыг зөв ангилан бүртгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг дахин давтахгүй анхаарч ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,001,678,730.98</u>	<u>1,170,210,571.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	619,018,957.46	759,256,277.87
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	253,848,683.61	266,824,711.42
31110	Төгрөг	253,848,683.61	266,824,711.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	365,170,273.85	492,431,564.45
3121	Төгрөг	365,170,273.85	492,431,566.45
31211	Төрийн сангийн харилцах	4,236,692.25	11,535,425.63
31213	Арилжааны банкин дахь харилцах	360,933,581.60	480,896,140.82
33	АВЛАГА	26,576,728.33	32,122,489.07
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	23,003,893.05	28,549,653.87
33401	Дансны авлага /ТӨҮГ/	3,572,893.05	3,572,835.20
35	БАРАА МАТЕРИАЛ	356,083,045.10	378,831,804.34
351	Түүхий эд материал	23,740,412.00	29,068,885.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	23,740,412.00	29,068,885.00
354	Хангамжийн материал	332,342,633.10	349,762,919.34
35410	Бичиг хэргийн материал	5,681,527.72	7,906,243.40
35420	Аж ахуйн материал	4,123,350.00	1,250,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	54,141,261.00	45,915,941.00
35440	Түлш, шатах тослох материал	637,333.75	670,000.00
35450	Барилгын засварын материал	66,521,660.00	81,732,110.00
35470	Бусад хангамжийн материал	201,237,500.63	212,288,624.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,021,638,785.35</u>	<u>9,374,885,787.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,021,638,785.35	9,374,885,787.84
391	Газар	685,905,540.00	685,905,540.00
392	Биет хөрөнгө	8,325,446,633.14	8,679,837,667.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,059,707,381.78	9,052,658,733.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,216,723.72	722,490,792.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	54,491,320.00	54,491,320.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	34,341,481.67	42,799,010.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	308,070,517.45	257,189,998.45

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ-ын
2019 оны санхүүгийн тайлангийн аудит

39206	Хуримтлагдсан элэгдэл	153,247,418.10	57,998,578.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,274,377.25	114,044,177.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	47,299,783.91	53,658,024.91
39209	Компьютер	99,862,094.83	99,862,094.83
39210	Хуримтлагдсан элэгдэл	71,853,650.77	71,853,650.77
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	50,391,400.00
393	Биет бус хөрөнгө	10,286,612.21	9,142,580.52
39301	Програм хангамж	25,555,704.56	17,997,050.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	15,269,092.35	8,854,469.48
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,023,317,516.24</u>	<u>10,545,096,359.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>92,720,785.47</u>	<u>71,986,464.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	92,720,785.47	71,986,464.97
413	Өглөг	950,102.84	32,135,951.00
4136	Бусад өглөг	950,102.84	32,135,951.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60,000.01	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	890,102.83	-
41365	Бусад богион хугацаат өр төлбөр	-	32,135,951.00
414	Урьдчилж орсон орлого	91,770,682.63	39,850,513.97
41440	Бусад урьдчилж орсон орлого	91,770,682.63	39,850,512.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,930,596,730.77</u>	<u>10,473,109,894.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,930,596,730.77	10,473,109,894.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,641,542,775.90	9,399,140,224.90
51101	Өмч: - төрийн	7,955,637,235.90	7,955,637,235.90
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	757,597,449.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	685,905,540.00	685,905,540.00
512	Хуримтлагдсан үр дүн	-1,959,275,269.62	-2,174,359,555.24
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,963,429,493.14	-1,959,275,269.62
51220	Тайлант үеийн үр дүн	4,154,223.52	-215,084,285.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,248,329,224.49	3,248,329,224.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,023,317,516.24</u>	<u>10,545,096,359.12</u>

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,417,321,451.45	5,438,208,836.70
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,861,426,952.63	5,168,959,983.94
3	Нийт ашиг (алдагдал)	555,894,498.82	269,248,852.76
5	Хүүний орлого	15,608,534.62	36,276,832.16
7	Эрхийн шимтгэлийн орлого	13,954,465.59	6,886,631.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал	579,280,841.66	523,868,918.63
12	Бусад зардал	1,560,853.46	3,627,683.22
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,615,803.91	(215,084,285.62)
19	Орлогын татварын зардал	461,580.39	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	4,154,223.52	(215,084,285.62)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,154,223.52	(215,084,285.62)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	4,154,223.52	(215,084,285.62)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	5,753,102,271.48	5,641,509,924.24
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,749,568,376.83	5,637,472,001.24
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,533,894.65	4,037,923.00
1.2	Мөнгөн гарсан дүн	5,446,390,696.01	6,439,957,458.99
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,707,361,660.00	1,840,154,607.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	479,907,686.85	537,584,958.47
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,442,058,050.91	3,737,901,036.59
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,885,370.00	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	410,330,709.70	3,242,312.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	152,234,935.32	148,083,608.97
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	828,914.26	
1.2.9	Шагнал урамшууллын зардал	17,562,131.00	3,696,000.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага	232,221,237.97	169,294,935.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	306,711,575.47	(798,447,534.75)
2.1	Мөнгөн орлогын дүн	15,608,534.62	36,276,832.16
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	15,608,534.62	36,276,832.16
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,608,534.62	36,276,832.16
3.1	Мөнгөн орлогын дүн	-	902,408,023.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		902,408,023.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	902,408,023.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	322,320,110.09	140,237,320.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	296,698,847.37	619,018,957.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	619,018,957.46	759,256,277.87

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,955,637,235.90		83,101,071.52	-1,852,629,714.49	0.00	6,186,108,592.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00		0.00	-110,799,778.65	0.00	-110,799,778.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,955,637,235.90		83,101,071.52	-1,963,429,493.14	0.00	6,075,308,814.28
Өмчид гарсан өөрчлөлт			0.00		685,905,540.00	685,905,540.00
Тайлант үеийн үр дүн	0.00		0.00	4,154,223.52	0.00	4,154,223.52
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт			3,165,228,152.97			3,165,228,152.97
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,955,637,235.90		3,248,329,224.49	-1,959,275,269.62	685,905,540.00	9,930,596,730.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,955,637,235.90	0.00	3,248,329,224.49	-1,959,275,269.62	685,905,540.00	9,930,596,730.77
Өмчид гарсан өөрчлөлт		757,597,449.00				757,597,449.00
Тайлант үеийн үр дүн				-215,084,285.62		-215,084,285.62
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	-2,174,359,555.24	685,905,540.00	10,473,109,894.15

4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

Дансны код	Эдийн засгийн зорилтот үзүүлэлт	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	/төгрөгөөр/ Хэтрэлт, хэмнэлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	5,234,900,430.00	5,481,372,300.17	246,471,870.17
	Төсөвт байгууллагад үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	5,106,725,050.00	5,225,795,296.95	119,070,246.95
	Өмчийн орлого	94,421,810.00	205,997,159.75	111,575,349.75
	Бусад орлого	33,753,570.00	13,303,011.31	(20,450,558.69)
	Хүүгийн орлого		36,276,832.16	36,276,832.16
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	5,234,900,430.00	5,696,456,585.79	(461,556,155.79)
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,182,400,430.00	5,643,327,808.79	- 460,927,378.79
2101	Цалин хөлсний зардал	2,314,998,900.00	2,523,335,162.47	- 208,336,262.47
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,057,776,800.00	2,241,086,541.62	(183,309,741.62)
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,222,100.00	282,248,620.85	(25,026,520.85)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,194,850,000.00	1,194,373,032.41	476,967.59
	Гэрэл, цахилгаан	708,500,000.00	708,097,998.14	402,001.86
	Түлш, халаалт	360,500,000.00	360,452,990.61	47,009.39
	Цэвэр, бохир ус	125,850,000.00	125,822,043.66	27,956.34
2104	Хангамж, бараа материалын зардал	343,550,000.00	347,581,337.47	- 4,031,337.47
	Бичиг хэрэг	11,000,000.00	8,492,760.32	2,507,239.68
	Тээвэр, шатахуун	17,700,000.00	17,721,349.75	(21,349.75)
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,000.00	4,542,034.88	(42,034.88)
	Ном, хэвлэл	500,000.00	204,600.00	295,400.00
	Хог хаягдал зайлуулах	41,900,000.00	41,125,000.00	775,000.00
	Хортон мэрэгчдийн устгал ариутгал	8,050,000.00	8,747,734.00	(697,734.00)
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	259,900,000.00	266,747,858.52	(6,847,858.52)
2105	Нормативт зардал	14,160,000.00	10,270,469.13	3,889,530.87
	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	800,000.00	848,063.80	(48,063.80)
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,360,000.00	9,422,405.33	3,937,594.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	511,050,000.00	573,009,262.47	- 61,959,262.47
	Багаж, техник, хэрэгсэл	20,350,000.00	29,905,573.64	(9,555,573.64)
	Тавилга	1,500,000.00	-	1,500,000.00
	Урсгал засвар	489,200,000.00	543,103,688.83	(53,903,688.83)

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ-ын
2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	97,410,000.00	97,104,844.00	305,156.00
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	4,200,000.00	-
	Даатгалын үйлчилгээ	900,000.00	832,396.00	67,604.00
	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,000.00		350,000.00
	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	302,504.00	47,496.00
	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	233,200.00	66,800.00
	Газрын төлбөр	5,100,000.00	5,002,900.00	97,100.00
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,210,000.00	4,547,300.00	(337,300.00)
	Харуул хамгаалалтын зардал	82,000,000.00	81,986,544.00	13,456.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	706,381,530.00	897,653,700.84	- 191,272,170.84
	Бараа, үйлчилгээний бусад зардал	79,300,000.00	68,864,254.33	10,435,745.67
	Элэгдлийн зардал	597,581,530.00	798,804,399.51	(201,222,869.51)
	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	23,500,000.00	24,144,000.00	(644,000.00)
	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	6,000,000.00	5,841,047.00	158,953.00
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,500,000.00	53,128,777.00	(628,777.00)
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,500,000.00	35,355,257.00	144,743.00
	Нэг удаагийн буцалтгүй тусламж	7,500,000.00	7,225,360.00	274,640.00
	Шагнал урамшуулал	9,500,000.00	10,548,160.00	(1,048,160.00)
	Хөрөнгийн зардал / данснаас хассаны олз, гарз /			-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019-12-31	Аудитын нэр: Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,	Аудитын код: САГ-2020/03/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ ТӨААТҮГ	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд гарсан 14.3 сая төгрөгийн шатахууны зардлыг удирдлагын зардлын ангилалд тээврийн зардлаар бүртгэж шатахууны зарцуулалтын тооцоо бодоогүй.	14.3	Зөвлөмж өгсөн	Захирал ,нягтлан бодогч	Б.Ундрам Д.Мөнхтуяа
2	Харуул хамгаалалтын албаны 12 дугаар сарын зардал 10.2 сая төгрөгийн өглөг үүсгээгүй	10.2	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	Б.Ундрам Д.Мөнхтуяа
	Нийт	24.5			

